



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20<sup>22</sup> он <sup>11</sup> дугаар  
сарын <sup>14</sup>-ны өдөр

Дугаар <sup>ХЗТ</sup> / 2758

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Намрын ургац хураалт болон өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг шинэчлэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт <sup>1</sup> хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225015443

# НАМРЫН УРГАЦ ХУРААЛТ БОЛОН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ


## Нэг. Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар

### 1.1. Өвөлжих малын тоо

Энэ жил улсын хэмжээнд нийт 188.6 мянган малчин өрхөд 71.2 сая, хонин толгойд шилжүүлснээр 122.5 сая толгой мал өвөлжих урьдчилсан дүн гарлаа. Үүнээс 2022-2023 оны өвөл, хавар өөр аймгийн бусад сумын нутагт 3.3 мянган өрх, 1.4 сая мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 5.0 мянган өрх, 2.4 сая мал, сум дундын отрын бүс нутагт 1.1 мянган өрх, 508.0 мянган мал, аймаг дундын отрын бүс нутагт 688 өрх, 455 мянган мал, хилийн зурвас бүс нутагт 3.9 мянган өрх, 1.5 сая мал, байгалийн тусгай хамгаалалттай бүс нутагт 7.7 мянган өрх, 3.2 сая мал, нийт 21.8 мянган өрх, 9.5 сая мал отроор өвөлжиж, хаваржих бэлтгэл хангагдсан бөгөөд өмнөх оноос 2.2 мянган малчин өрх, 1.1 сая малаар өссөн байна.

### 2022-2023 ОНЫ ӨВӨЛ, ХАВАР ОТОРЛОХ ӨРХ, МАЛЫН ТОО

№	Отрын бүс	Оторлох	
		Малчин өрхийн тоо	Малын тоо (мян.тол)
1.	Өөр аймгийн нутагт	3321	1402.0
2.	Өөрийн аймгийн бусад сумын нутагт	5021	2363.0
3.	Сум дундын отрын бүс нутагт	1147	508.0
4.	Аймаг дундын тусгай хэрэгцээний нутагт	688	455.0
5.	Хилийн зурвас бүс нутагт	3922	1557.0
6.	Байгалийн тусгай хамгаалалттай бүс нутагт	7704	3240.0
<b>Нийт</b>		<b>21803</b>	<b>9525.0</b>



Отрыг байршлаар нь авч үзвэл 34.0 хувь нь байгалийн тусгай хамгаалалттай бүс нутагт, 24.8 хувь нь өөрийн аймгийн бусад сумын нутагт, 16.3 хувь нь хилийн зурвас бүсэд, 14.7 хувь нь өөр аймгийн нутагт, 4.8 хувь нь аймаг дундын отрын бүс нутагт, 5.3 хувь нь сум дундын отрын бүс нутагт өвөлжихөөр байна.

## 1.2. Мал, мах бэлтгэлийн талаар

Улсын хэмжээнд 2021 оны эцсийн мал тооллогоор 67.3 сая толгой мал тоологдож, 2022 онд 24.0 сая толгой төл бойжуулснаар өнөөдрийн байдлаар 90 орчим сая мал бэлчээрлэж байна.

2022-2023 оны өвөл, хавар 19.9 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулан 71.2 сая толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан дүн мэдээтэй байна.

### ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ МАЛЫН ТООНЫ СУДАЛГАА

д/д	Аймгийн нэр	2021 онд хэрэгцээлсэн малын тоо (мян.тол)	2022 онд хэрэгцээлэх малын тоо (мян.тол)	Өсөлт, бууралт	
				Тоогоор (мян.тол)	Хувиар
1	Архангай	1,177.8	1,411.4	233.6	19.8
2	Баян-Өлгий	663.3	675.0	11.7	1.8
3	Баянхонгор	325.0	884.9	559.9	172.3
4	Булган	1,160.2	1,189.6	29.4	2.5
5	Говь-Алтай	839.8	1,256.6	416.8	49.6
6	Говьсүмбэр	155.1	133.2	(21.9)	(14.1)
7	Дархан-Уул	104.6	103.8	(0.8)	(0.8)
8	Дорноговь	356.0	434.6	78.6	22.1
9	Дорнод	628.3	904.4	276.1	43.9
10	Дундговь	824.3	661.4	(162.9)	(19.8)
11	Завхан	591.8	967.6	375.8	63.5
12	Орхон	46.0	49.2	3.2	6.9
13	Өвөрхангай	905.2	1,290.5	385.3	42.6
14	Өмнөговь	322.7	483.2	160.5	49.7
15	Сүхбаатар	1,197.2	1,285.7	88.5	7.4
16	Сэлэнгэ	380.3	546.3	166.0	43.7
17	Төв	1,456.3	1,709.5	253.2	17.4
18	Увс	1,637.3	1,413.0	(224.3)	(13.7)
19	Ховд	650.3	604.0	(46.3)	(7.1)
20	Хөвсгөл	1,730.2	1,824.0	93.8	5.4
21	Хэнтий	1,501.8	1,440.0	(61.8)	(4.1)
22	Улаанбаатар	79.0	76.8	(2.2)	(2.8)
<b>Нийт</b>		<b>16,732.4</b>	<b>19,944.7</b>	<b>2,612.3</b>	<b>15.6</b>

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар зөвлөмжөөр үхрийн түүхий мах 8.0 тн, дулааны аргаар боловсруулсан үхрийн мах 5.0 мянган тн-ыг, харин адуу, хонь, ямааны түүхий болон дулааны аргаар боловсруулсан махыг бодлогын гэрээний үндсэнд хязгаарлалтгүй экспортлохоор баталсан.

Энэ хүрээнд Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудаас Казахстан, Иран улсууд руу адууны махны экспорт хийгдэн эхэлж байгаа бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар адууны мах 2.9 мянган тн, хонь, ямааны түүхий мах 3.4 мянган тн, нийт 6.3 мянган тн мах экспортлоод байна.

Хот суурин газрын хүн амын хаврын махны нөөцөд зориулан Засгийн газрын 2022 оны 174 дүгээр тогтоолоор нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд 130.0 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд улсын төсвөөс олгох татаасыг тухайн зээлийн нийт хүүгийн 10.5 хувьтай тэнцэх хэмжээгээр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх тогтоолын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 4 аж ахуйн нэгжид Хаан, Худалдаа хөгжлийн банкуудаар 38.3 тэрбум төгрөг олгогдоод байна. Харин аймгуудын мэдээллээр 2.5 мянган тн мах нөөцлөхөд зориулж 1.1 тэрбум төгрөг төсөвлөжээ.

### 1.3. Хадлан, тэжээл бэлтгэлийн талаар

Мал аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд малчдын түвшинд 1.3 сая тн өвс, 14.9 мянган тн сүрэл, 88.5 мянган тн ногоон тэжээл, 57.4 мянган тн үйлдвэрийн тэжээл, 88.6 мянган тн гар тэжээл, 13.1 мянган тн дарш, 116.9 мянган тн давс, хужир, шүү бэлтгэхээр төлөвлөсөн. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 25.3 мянган тн өвс, 12.6 мянган тн тэжээл бэлтгэх үүрэг өгсөн.

Энэ жилийн хадлан тэжээл бэлтгэлийн ажилд улсын хэмжээнд 4566 дугуйт трактор, үүнээс 3067 бага оврын трактор, 2033 ангилан хадагч, 747 морин хадуур, 30107 гар хадуур, 3113 тармуур, 520 хаман боогч, 30 нуруулдагч, 1637 тракторын чиргүүл ажиллалаа.

Булган, Дархан-Уул, Дорнод, Орхон, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудад өөрийн аймгийн 44836 иргэн, 354 аж ахуйн нэгж нийт 583.3 мянган га талбайд, Дархан-Уул, Сүхбаатар, Дорнод аймгуудад гадны аймгийн 73 иргэн, 8 аж ахуйн нэгж 16.0 мянган га талбайд түрээсээр хадлан бэлтгэх ажил хийгдлээ.

### ӨВС ТЭЖЭЭЛИЙН БЭЛТГЭЛИЙН ЯВЦ

Тэжээлийн төрөл		Бэлтгэвэл зохих (мян.тн)	Бэлтгэсэн (мян.тн)	Хувь
Малчдын түвшинд	Өвс	1271.8	1138.2	89.5
	Сүрэл	14.9	15.0	100.0
	Ногоон тэжээл	88.5	88.0	99.4
	Хүчит тэжээл	57.4	32.4	56.4
	Гар тэжээл	88.6	47.9	54.1
	Дарш	13.1	13.1	100.0
	Хужир, шүү	116.9	92.2	78.9
Аймаг, сумын аюулгүйн нөөц	Өвс	25.3	21.0	83.0
	Тэжээл	12.6	8.2	65.1

Өвөлжилтийн бэлтгэл хүлээн авахад малчдын түвшинд 1.1 сая тн өвс, 15.0 мянган тн сүрэл, 88.0 мянган тн ногоон тэжээл, 32.4 мянган тн үйлдвэрийн тэжээл, 47.9 мянган тн гар тэжээл, 13.1 мянган тн дарш, 92.2 мянган тн хужир, шүүг тус тус бэлтгэсэн. Энэ нь бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн 84.5 хувийг эзэлж байна.

Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 21.0 мянган тн өвс, 8.2 мянган тн тэжээл бэлтгэсэн байна. Түүнчлэн аймгуудын зах дээр 4.0 мянган тн өвс, 1.7 мянган тн тэжээл байгаа мэдээтэй байна.

Аймгуудаар авч үзвэл Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан аймгийн малчдын өвс, тэжээлийн биелэлт 50-иас доош хувьтай, аюулгүйн нөөцийн хувьд Завхан, Хөвсгөл аймгууд 50-иас доош хувьтай байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлээс тарьсан ногоон тэжээл, гурилын үйлдвэрээс гарах тэжээл, тэжээл рүү шилжиж буй улаанбуудай зэргээс 220.0 мянган тн хүчит тэжээл бэлтгэгдэнэ. Мөн баруун аймгууд жилд 25-30 мянган тн хүчит тэжээл импортолдог бөгөөд энэ жилийн хувьд нэмэгдэх төлөвтэй байна.

#### **1.4. Худаг ус, хашааны хангамжийн талаар**

Улсын хэмжээнд 52344 уст цэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс инженерийн хийцтэй худаг 16092, энгийн уурхайн худаг 34887, усан сан 465 байна. Энэ онд ашиглахад бэлэн худаг 48259 буюу 91.8 хувь, нийт малчин өрхийн 92.5 хувь усаар хангагдсан дүнтэй гарлаа.

2022 онд нийт 11.3 тэрбум төгрөгөөр 673 худаг гаргаснаас улсын төсвийн 2.2 тэрбум төгрөгөөр 71 худаг, орон нутгийн төсвийн 8.4 тэрбум төгрөгөөр 445 худаг, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн 655.7 сая төгрөгөөр 24 худаг, малчид өөрийн хөрөнгөөр 165 худаг хүлээн авлаа. Ингэснээр 975.0 мянган га бэлчээр, 3195 малчин өрх, 1.7 сая малын усан хангамжийг нэмэгдүүллээ.

Энэ онд бодын 1542, богийн 3133 хашаа саравч шинээр барьсан бөгөөд улсын хэмжээнд бодын 89.4 мянган хашаа, богийн 158.6 мянган хашаа байгаа буюу хашааны хангамж 97.6 хувьтай байна.

Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг үлийн цагаан огтонотой тэмцэх 2022 оны хаврын ажлыг 250.0 мянган га-д гүйцэтгэсэн бол намрын ажлыг 289.0 мянган га-д үлийн цагаан огтонотой, 30.5 мянган га-д царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулснаар мал аж ахуйн үйлдвэрлэлд 570.0 мянган га бэлчээрийг эргэлтэд орууллаа. Энэ онд бэлчээрийн ургамал хамгааллын ажилд орон нутгийн төсвөөс 505.0 сая төгрөг зарцуулсан.

#### **1.5. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар**

##### **Шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Шүлхий өвчний гаралт 2022 онд нийт 20 аймгийн 203 суманд 460 голомт бүртгэгдсэн бөгөөд шүлхий өвчинтэй тэмцэх стратегийг өөрчлөн тэмцсэний үр дүнд гаралт, тархалтыг зогсоож, улсын хэмжээнд хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байгаа аймаг, сум байхгүй, тайван байна.

Шүлхий өвчний эсрэг масс дархлаажуулалтын арга хэмжээний хүрээнд энэ онд нийт 21 аймаг, нийслэлийн 336 сум, дүүргийн давхардсан тоогоор 13.0 сая толгой үхэр, гахай, цаа бугыг хамруулаад байна. Вакцины дархлааны идэвхийг шалгахад үхэр сүрэгт 96.0 хувьд дархлаа үүссэн байна.

Өвөлжилтийн бэлтгэлийг хангах, нөөц бүрдүүлэх зорилгоор “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд Оросын Холбооны Улсаас 1.9 сая ам.долларын өртөг бүхий 3 серийн 6.5 сая тун шүлхийн вакциныг 11 дүгээр сарын 3-ны өдөр хүлээн авч, Биокомбинат ТӨХХК-ийн тусгай зориулалтын хөргүүрт хадгалаад байна.

#### Үхрийн арьс товруутах өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Үхрийн арьс товруутах өвчин нийт 5 аймгийн 11 сумын 21 голомтод оношлогдож, одоогийн байдлаар Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн 3 сумын 6 голомтод хорио цээрийн арга хэмжээ хэрэгжиж байна. 10 дугаар сарын 11-ний өдрөөс хойш өвчлөл дахин нэмэгдээгүй, халдварын тархалтыг бүрэн хяналтад авсан байдалтай байна.

Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтад 1.1 сая толгой үхэр хамруулахаас 97.4 хувийн гүйцэтгэлтэйгээр таригдаж дууссан.

Тус өвчний гаралт 2021 онд нийт 3 аймгийн 20 суманд 60 голомтод оношлогдож, 2682 толгой үхрийг зайлшгүй шаардлагаар устгасан бол 2022 онд 5 аймгийн 11 сумын 21 голомтод хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлж, 1255 толгой үхрийг зайлшгүй шаардлагаар устгалд хамруулсан.

Үхрийн арьс товруутах өвчинтэй тэмцэх, өвчилсөн үхрийг зориудаар устгасан арга хэмжээний 2021 оны нөхөн төлбөрт шаардлагатай 3.4 тэрбум төгрөгийг Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны төсвийн төсөлд тусгаад байна.

#### Бог малын мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Бог малын мялзан өвчин 2022 он гарсаар нийт 9 аймгийн 44 сумын 70 голомтод оношлогдож, хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар Архангай аймгийн 3, Булган аймгийн 4, Дорноговь аймгийн 1, Дундговь аймгийн 2, Хэнтий аймгийн 1, Хөвсгөл аймгийн 1 суманд тус тус хорио цээрийн дэглэм хэрэгжиж байна.

Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 7-9 дүгээр сард хэрэгжүүлэн нийт 6 аймгийн 24 сумын 4133 өрхийн 2.2 сая толгой бог малыг хамруулсан хэдий ч одоо бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины нөөц Мал эмнэлгийн ерөнхий газарт байхгүй байгаа нь уг өвчинтэй тэмцэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгээд байна.

#### Хонины цэцэг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хонины цэцэг өвчний гаралт 2022 оны 9 дүгээр сараас хойш 3 аймгийн 4 суманд бүртгэгдэж, одоогийн байдлаар Дорнод аймгийн 1 суманд хорио цээрийн арга хэмжээ хэрэгжиж байна. Өвчний гаралт 10 дугаар сарын 10-ны өдрөөс хойш дахин нэмж бүртгэгдээгүй.

Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх 3.0 сая тун вакциныг Биокомбинат ТӨХХК-аас худалдан авч, эрсдэл бүхий 4 аймгийн 2.3 сая толгой хонин сүргийг дархлаажуулахаар вакциныг хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийн явц 11 дүгээр сарын 10-ний өдрийн байдлаар 84.7 хувьтай байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын нөөцөд хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх 462.8 мянган тун вакцин хадгалагдаж байна.

### **1.6. Нэгдсэн дүн**

Энэ жилийн хувьд улсын дунджаар малын тарга хүч, малчдын өвс, тэжээлийн бэлтгэл, хашаа саравч засаж тохижуулсан, ариутгал халдваргүйтгэл хийлгэсэн, хоол хүнс, түлээ түлшний нөөц, хүн, мал эмнэлгийн эмийн сан, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан байдлаар дүгнэхэд өрхийн бэлтгэл 90.2 хувьтай байна.

Харин улсын хэмжээнд мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг малчдын өвс, тэжээл бэлтгэл, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтүүдээр дүгнэхэд 87.4 хувьтай хангагдаад байна.

### **Хоёр. Ургац хураалтын ажлын талаар**

#### **2.1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал**

Монгол Улс нийтдээ 1050.0 мянган га тариалангийн эргэлтийн талбайтай бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 898.0 мянган га талбайд үр тарианы чиглэлээр 1450 иргэн, аж ахуйн нэгж, төмс, хүнсний ногооны чиглэлээр 852 аж ахуйн нэгж, 17.1 мянган иргэн, жимс, жимсгэнийн чиглэлээр 340 аж ахуйн нэгж, 2.5 мянган иргэн тариалан эрхэлж байна.


2022 онд улсын хэмжээнд 378.1 мянган га-д үр тариа, үүнээс 353.1 мянган га-д улаанбуудай, 19.9 мянган га-д төмс, 11.1 мянган га-д хүнсний ногоо, 57.4 мянган га-д малын тэжээл, 117.4 мянган га-д тосны ургамал, 4.6 мянган га-д жимс, жимсгэнэ, нийтдээ 588.5 мянган га-д тариалалт хийж, 310.0 мянган га-д уринш боловсруулж бэлтгэсэн байна.

Энэ оны ургацын урьдчилсан балансаар 470.3 мянган тн үр тариа, үүнээс 441.4 мянган тн улаанбуудай, 234.1 мянган тн төмс, 125.8 мянган тн хүнсний ногоо, 55.7 мянган тн тосны ургамал, 104.4 мянган тн малын тэжээлийн ургамал тус тус хураан авах боломжтой гэсэн төлөв гарсан.

Урьдчилсан балансаас харахад улаанбуудай, төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны 70 хувь, таримал тэжээлийн 50 хувь, тослог ургамлын 32 хувийг дотоодын ургацаас хангах боломж бүрдэж байгаа бөгөөд хүнсний ногооны үйлдвэрлэл өнгөрсөн жилийнхээс 10 гаруй хувиар өсөхөөр байна.

Ургацын урьдчилсан балансаар гурил үйлдвэрлэлд нийтдээ 334.7 мянган тн буудай нийлүүлэгдэх төлөвтэй байна. Манай улсын жилийн хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэхэд 310.0 мянган тн цэвэр хүнсний улаанбуудай шаардлагатай бөгөөд балансаас харахад 2022-2023 оны хэрэгцээг хангах хэмжээний улаанбуудай хураан авах урьдчилсан баланс гарсан.


Улаанбуудай тариалсан талбай, хураан авсан ургац (2017-2022 он)  
/2022 оны хувьд хүлээгдэж буй гүйцэтгэлээр/



Төмсний үйлдвэрлэл (2017-2022 он)  
/2022 оны хувьд хүлээгдэж буй гүйцэтгэлээр/



Хүнсний ногооны үйлдвэрлэл (2017-2022 он)  
/2022 оны хувьд хүлээгдэж буй гүйцэтгэлээр/





## 2.2. Ургац хураалтын төлөв байдал, явцын мэдээлэл (2022.11.08)

Ургац хураалтын явц 11 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар 332.0 мянган га-гаас 401.7 мянган тн үр тариа, үүнээс 310.7 мянган га-гаас 378.3 мянган тн улаанбуудай, 19.4 мянган га-гаас 210.3 мянган тн төмс, 11.9 мянган га-гаас 136.6 мянган тн хүнсний ногоо, 62.6 мянган га-гаас 158.5 мянган тн тэжээлийн ургамал, 102.5 мянган га-гаас 41.3 мянган тн тосны ургамал тус тус хураан авсан мэдээтэй байна.

Д/д	Таримлын төрөл	Хураах талбай (га)	Хураасан талбай (га)	Хувь	Нэгжийн ургац (цн)	Нийт ургац (тн)
	Үр тариа	353,492	332,023	95.1	12.1	401,750
1	<b>Үүнээс: Улаанбуудай</b>	<b>329,109</b>	<b>310,700</b>	<b>94.4</b>	<b>12.1</b>	<b>378,340</b>
2	Төмс	19,881	19,362	97.4	108.6	210,292
3	Хүнсний ногоо	11,114	11,857	106.7	115.2	136,651
4	Тэжээл	67,931	62,625	92.1	25.3	158,455
5	Тосны ургамал	115,244	102,540	88.9	4.0	41,279

Ургац хураалтад нийтдээ 1095 комбайн, 620 ширхэг жатка, 230 гаруй үтрэм, 1035 ширхэг үр тариа цэвэрлэх, сортлох, ачих машин, 75 ширхэг төмс хураах комбайн, 510 ширхэг төмс ухагч, ангилах, сортлох машин ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн үр дүнд дилер аж ахуйн нэгжүүд өндөр хүчин чадлын 40 гаруй комбайныг ургац хураалтын өмнө нийлүүлж, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр ургац хураалтын ажлыг 25-30 хоногт багтаан дуусгах боломжийг бүрдүүлсэн.

Ургацыг мал амьтнаас хамгаалах, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн хураасан ургацын мэдээг үнэн зөв гаргаж, улсын нэгдсэн мэдээ тайланд тусгуулахад онцгой анхаарах чиглэлээр Улсын ургацын комиссын даргын албан даалгавар гарч, орон нутагт хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд арилжааны 7 банкаар дамжуулан газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 460 аж ахуйн нэгж, иргэнд 72.0 тэрбум төгрөг, төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 973 иргэн, аж ахуйн нэгжид 28.0 тэрбум төгрөг, нийтдээ тариалан бүхий 1433 иргэн, аж ахуйн нэгжид 100.0 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэн тариалалт, уринш боловсруулалт, хог ургамал, өвчин хортонтой тэмцэх, ургац хураалтын ажлыг агротехнологийн хугацаанд явуулах боломжийг бүрдүүлэв.

Засгийн газрын 2022 оны 276 дугаар тогтоолын дагуу ургацад ажиллах хүн хүчний захиалга судалгааг авч хэрэгжилтийг зохион байгуулснаар 5 их, дээд сургууль, Зэвсэгт хүчний жанжин штабын 18 анги нэгтгэлээс нийтдээ 3102 оюутан, сонсогч, цэргийн албан хаагчид ургац хураалтад оролцохоор аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ургац хураалтад ажиллаж байна.

Томоохон хот, суурин газарт улаанбуудай, төмс, хүнсний ногоо ачсан хүнд даацын тээврийн хэрэгслэл орох боломжийг бүрдүүлэх, ургац тээвэрт ашиглагдах зам, гүүрийн эвдрэл гэмтлийг мэргэжлийн байгууллагуудаар шалган тогтоолгож, шуурхай засварлуулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Мөн ногооны зорь, агуулах, үтрэмийн цэвэрлэгээ ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавьж ажиллах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудад санал хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Улсын хэмжээнд үр тариа хадгалах 550.2 мянган тн-ын багтаамжтай төмөр бетон элеватор байгаагаас Хөдөө аж ахуйг дэмжих санд 186.0 мянган тн, хувийн хэвшилд 364.2 мянган тн нь ашиглагдаж байгаа бөгөөд элеваторуудын ариутгал, засвар үйлчилгээ хийгдэж, буудай хүлээн авч эхлээд байна. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн элеваторуудад 3.0 мянга гаруй тн улаанбуудай өр төлбөрт аваад байна.

### **2.3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар**

1. Ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор “Намрын ногоон өдрүүд-2022” нэгдсэн арга хэмжээ, үзэсгэлэн худалдааг Улаанбаатар хотод 9 дүгээр сарын 19-25-ны өдрүүдэд зохион байгуулж, нийслэлийн 9 дүүрэг, 16 аймгийн 23 сумын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийг оролцуулж, нийт 1.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн.
2. Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоог хямд үнээр борлуулах, ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран 9 дүүргийн 31 байршилд томоохон хэмжээний хүнсний ногоо борлуулах төвлөрсөн цэг байгуулан ажиллуулж байгаа бөгөөд эдгээр цэгүүдэд 7 хоногт 28 нэр төрлийн 5.6 мянган тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулж байна.
3. Хаврын тариалалтад зориулан Хөдөө аж ахуйг дэмжих сангаас улаанбуудайн 9400 тн дотоодын болон 936.6 тн импортын үрийг 263 аж ахуйн нэгж, иргэнд, хошуу будааны 467.3 тн үрийг 44 иргэн, аж ахуйн нэгжид, царгасны 820 кг үрийг 9 аж ахуйн нэгж, иргэнд, арвайн 10 тн үрийг 5 аж ахуйн нэгж, иргэнд 30 хувийн урьдчилгаатай зээлээр олгож тариалуулав. Хүнсний ногооны 48.1 тн үрийг 113 аж ахуйн нэгж, иргэнд 8 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож тариалалтад дэмжлэг үзүүлэв.
4. Хаврын тариалалт, уринш боловсруулалт, ургамал хамгааллын арга хэмжээнд зориулан 185 аж ахуйн нэгж, иргэнд 1.1 мянган тн шатахуун, 136 аж ахуйн нэгж, иргэнд 104115 литр ургамал хамгаалах бодис, 75 аж ахуйн нэгж, иргэнд 49.5 тн бордоо хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож дэмжлэг үзүүлэв.
5. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр нийлүүлэгдсэн дарш хураагч, бууц цацагч, бордоо цацагч, чиргүүл, анжис, үрлүүр зэрэг 29 ширхэг тоног төхөөрөмж, 118 ширхэг 1-100 га услах усалгааны төхөөрөмж, ОХУ-ын хөнгөлөлттэй зээлээр нийлүүлэгдсэн 11 ширхэг борной, чиргүүл үрлэгч, өвс хаман боогч, Беларусь Улсын хөнгөлөлттэй зээлээр нийлүүлэгдсэн 50 ширхэг трактор, хадуур тармуур, хаман боогч, анжис үрлүүрийг тус тус хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлээр олгож, тариалангийн үйлдвэрлэлийн технологийг сайжруулав.

6. Алслагдсан бүсэд үр тариа хадгалах агуулахын хангамжийг сайжруулах, тариалаланчдын тээврийн өртгийг бууруулах зорилгоор улсын төсвийн 2.4 тэрбум төгрөгөөр Дорнод аймгийн Хэрлэн суманд 10.0 мянган тн багтаамжтай үр тариа хадгалах зориулалттай элеваторын суурь байгуулах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.
7. Газар тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн эрсдэлээс хамгаалах, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны 40.0 сая ам.долларын зээл болон Японы ядуурлыг бууруулах сангийн 2.0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгуудад 2731 га талбай бүхий 9 услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах ажлыг эхлүүлэн 2023 онд ашиглалтад хүлээн авч, усалгаатай тариалангийн эргэлтэд нэмж оруулахаар ажиллаж байна.
8. Улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Увс аймгийн Улаангом сумын Арсайн газар тариалангийн услалтын системийг шинээр барих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулж, зураг төсөл боловсруулах ажлыг хийж байна.
9. Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих Шинэ хөдөө төсөл (Төв аймаг, 27 сум)-ийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, улсын төсвийн 3.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 90 морины хүчтэй 22 иж бүрдэл трактор, үрлүүр, хадуур, хаман боогч нийлүүлэх гэрээг байгуулав.
10. Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл (улсын хэмжээнд)-ийн хүрээнд бараа худалдан авах 5 багц тендерийн 3 багцад гэрээ байгуулан 120 м.кв талбай бүхий 42 иж бүрдэл хүлэмж болон 27 иж бүрдэл усалгааны тоног төхөөрөмжийг нийлүүлж, хүлээн аваад байна.
11. Улсын төсвийн 900.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 400 м.кв өвөл, зуны хүлэмжийн цогцолбор бүхий Агро ойн аж ахуй, Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 500 м.кв өвлийн хүлэмж байгуулж байна.
12. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгөөр төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай зоорийн байгууламжийг байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.
13. Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгөөр Зоорь, хүлэмжийн байгууламж байгуулах тендерийг 3 багцтайгаар зарласнаас 2 дугаар багц буюу Хүлэмжийн байгууламж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгч 60 иж бүрдэл 3600 м.кв хүлэмжийн байгууламжийг байгуулж улсын комисст хүлээлгэн өгсөн.
14. 2021-2022 онд төмс, хүнсний ногооны 500, 1000, 2500 тн агуулахын нэг маягийн зураг, төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулан бэлэн болгов.
15. Газар тариалангийн дунд оврын иж бүрэн трактор (Говь-Алтай аймаг, Бугат сум, Тахийн тал, Халиун, Шарга) тендер шалгаруулж, 299.9 сая төгрөгийн үнэ бүхий 120 м.х трактор 1 ширхэг, 90 м.х трактор 1 ширхэг, анжис 1 ширхэг, хаман боогч 1 ширхэгийг нийлүүлэх гэрээг байгуулав.
16. Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж (Ховд аймаг) тендер шалгаруулалт зохион байгуулж, 259.1 сая төгрөгөөр 75 м.х трактор, роторт сийрүүлүүр, сармисны булцуу суулгагч, хүнсний ногооны үрлүүр, хүнсний ногооны ухагч бүхий 1 иж бүрдэл техник тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулаад байна.

17. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд улсын төсвийн 250.0 сая төгрөгөөр Говьсүмбэр аймаг болон Төв аймгийн Борнуур суманд жимс, жимсгэний суулгац үржүүлгийн төв байгуулж, дотооддоо суулгац үржүүлэх боломж бүрдүүлж байна.
18. Дараа оны тариалалтад зориулан чанар сайтай 5000 тн үрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.
19. Үр ариутгалын бодис, эрдэс болон органик бордоо, ургамал хамгааллын бодисын зохих нөөц бүрдүүлэх чиглэлээр тариалан эрхлэгчид болон Хөдөө аж ахуйг дэмжих сан, ургамал хамгааллын бодис, бордоо импортлогч аж ахуйн нэгжүүдэд чиглэл хүргүүлж, технологийн хугацаанд нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

#### **2.4. Салбарын өмнө тулгамдаж буй асуудал**

- Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр импортоор авдаг бордоо, ургамал хамгааллын бодис, техник, тоног төхөөрөмжийн үнэ нэмэгдсэн, нийлүүлэлт удааширсан зэрэг нь тариалангийн үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж байгаа ба энэ эрсдэл цаашид үргэлжлэх төлөвтэй байна.
- Цаг уурын нөхцөл байдлаас хамаарч улаанбуудайн ургацын болц харилцан адилгүй байснаас ургац хураалт зарим газруудад оройтож болзошгүй байна.
- Гурилын үйлдвэрүүд зөвхөн цавуулаг өндөртэй будаа авах сонирхолтой байгаагаас стандартын шаардлага хангаж байгаа боловч 18-22 хувийн цавуулаг багатай улаанбуудай борлуулагдахгүй үлдэх хандлагатай байна.
- Иймд стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор хүнсний улаанбуудай худалдан авах ажлыг эхлүүлээд байна. "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасны дагуу 2023 оны улсын төсөвт улаанбуудай худалдан авахад зориулж 35.0 тэрбум төгрөгийг тусгасан.
- Цаашид эргэлтийн хөрөнгийн сантай болсноор жил бүр 100.0 мянгаас доошгүй тн хүнсний болон үрийн улаанбуудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, улмаар улаанбуудайн хангамж, үнийг тогтворжуулах нөхцөл бүрдэнэ.

-----oO-----